



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 5/26

Ховд

┌ Бүтэц баталсан тушаалын хавсралтад ┐
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/127 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний зарим албан хаагчдын цалингийн шатлалд өөрчлөлт оруулсугай.

2. Цалингийн шатлалд нь өөрчлөлт оруулах албан хаагчдын цалингийн шатлалыг хавсралтаар баталсугай.

3. Цалингийн шатлалд нь өөрчлөлт орсон албан хаагчдын цалинг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн өөрчилсөн шатлалаар тооцож, холбогдох нэмэгдлийг бодож олгохыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Б.Ганболд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.САНДАГСҮРЭН

Засаг даргын Тамгын газрын даргын
2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн
Б/26 дугаар тушаалын хавсралт



ЦАЛИНГИЙН ШАТЛАЛД НЬ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН АЛБАН ХААГЧДЫН НЭРС

Д/д	Албан тушаал	Өмнөх шатлал	Шинэчилсэн шатлал
1	Бичиг хэргийн эрхлэгч	ТҮ-5	ТҮ-7
2	Бичиг хэргийн оператор	ТҮ-4	ТҮ-6
3	Бичиг хэргийн оператор	ТҮ-4	ТҮ-6
4	Архивын тасгийн арга зүйч	ТҮ-4	ТҮ-6
5	Архивын тасгийн Сан хөмрөгийн сэлбэн засагч	ТҮ-2	ТҮ-6
6	Архивын тасгийн Сан хөмрөгийн архивч	ТҮ-2	ТҮ-6
7	Архивын гэрээт ажилтан	ТҮ-2	ТҮ-4
8	Архивын гэрээт ажилтан	ТҮ-2	ТҮ-4

-оОо-